



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар Б/116

Хэрлэн сум

**Б.Есөнжинг туршилтын хугацаагаар
ажилд томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалт, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт, Монгол Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 82 дугаар тогтоол, 2024 оны “Тогтоолд нэмэлт оруулах тухай” 171 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын туслахаар Баярсайханы Есөнжинг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс туршилтын 1 сарын хугацаагаар томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын

дарга: Ч.Баярцолмон Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: О.Ган-Эрдэнэ Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн цахимжуулалт хариуцсан ажилтан

Т.Баяртуяа Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав

3. Б.Есөнжингийн сарын үндсэн цалинг 1,757,000 (нэг сая долоон зуун тавин долоо мянга) төгрөгөөр, орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар, онцгой нөхцөлийн нэмэгдлийг 30 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Б.Есөнжингийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комисс (Ч.Баярцолмон)-д даалгасугай.

5. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Есөнжинд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА